Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 403262,2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8065,2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 516408,0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10328,1 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 781992.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 15035.7 мянган төгрөгөөр буюу 1,8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, Засгийн газрын оролцоо данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 48,665.5 | 47,228.3 | (1,437.2) |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 10,000.0 | 20.4 | (9,979.6) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 38,665.5 | 47,207.9 | 8,542.4 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 748,362.3 | 734,763.8 | (13,598.5) |
| Үндсэн хөрөнгө | 791,313.4 | 806,561.9 | 15,248.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | (42,951.1) | (71,798.0) | (28,847.0) |
| **Нийт хөрөнгө** | 797,027.8 | 781,992.1 | (15,035.7) |
| Өр төлбөр | 4,906.1 | - | (4,906.1) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 792,121.7 | 781,992.1 | (10,129.6) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 797,027.8 | 781,992.1 | (15,035.7) |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Өмнөх оны авлагыг бүрэн барагдуулсан болович 20,4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу шилжүүлснээс үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 47207,8 мянган төгрөг болж 8542,3 мянган төгрөгөөр өссөн нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас 140,0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн тусгай зориулалтын материалын дансанд 4468,0 мянга, эм боох материалын тайлан тусгаарлах өрөөний тохижуулахаар худалдан авсан 1634,0 мянга, барилгын материалын дансанд 2820,0 мянган төгрөгийн үлдэгдлээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 806561,8 мянган төгрөг болж 15248,5 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх онд авлагаар тусгасан 10000,0 мянган төгрөгийн гадна талбайн



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

тоглоом, үнэ төлбөргүй хүлээн авсан 5248,5 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 5248,5 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, өмнөх оны авлагаар төлбөрийг төвлөрүүлж гүйцэтгүүлсэн 10000,0 мянган төгрөгийг хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өмнөх онд ажиллагсадтай холбоотой хувь хүний орлогын албан татварын, нийгмийн даатгалын шимтгэлийн 4906,1 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөрийг бүрэн барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 781992,0 мянган төгрөг болж 10129,5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 10575.0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 506278,4 мянган төгрөг болж, өмнөх оноос 86761,5 мянган төгрөгөөр буюу 20,6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Төсөвт байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 3048,5 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого өмнөх оноос нэмэгдсэнтэй, тусламж санхүүжилтийн орлого 83573,0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 17512,7 мянган төгрөгөөр нэмэгдэж, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 1589,4 мянган төгрөгөөр буурсан, нэмэлт санхүүжилтийн орлого 67649,7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал 516408,1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 115187,2 мянган төгрөгөөр буюу 28,7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, хангамж бараа материалын зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, элэгдлийн зардал нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 514020,0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 514020,2 мянган төгрөгөөр, хүүхдийн тоог 195, ажиллагсдын тоог 26 орон тоогоор тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 23558,8 мянган төгрөгөөр бууруулж 490461,4 мянган төгрөг, хүүхдийн тоог 205, ажиллагсдын тоог 26 орон тоогоор баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 490461,4 мянган төсөв батлагдаж 3 удаа тодотгол хийн 433240,2 мянган төгрөгийн төсөв баталснаас 366701,6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 66538,6 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 67538,6 мянга, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 365701,6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 422927,9 мянган төгрөгийг зарцуулж 10312,2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 422927,9 мянган төгрөг буюу 97,6 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 101,2 байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 1165,2 мянга, хангамжийн материалын зардлыг 69,5 мянга, нормативд зардлыг 631,3 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 8185,2 мянга, томилолтын зардлыг 120,1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээний 10312,2 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Төсийн гүйцэтгэлийн тайлан /хөтөлбөр, арга хэмжээгээр/ төгрөгөөр

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| ХӨТӨЛБӨР 71801 Сургуулийн өмнөх боловсрол | 433,240,200.00 | 422,927,978.22 | 10,312,221.78 | 97.6 |
| АРГА ХЭМЖЭЭ 80109 Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардал | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 66,538,600.00 | 65,373,330.00 | 1,165,270.00 | 98.2 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 66,538,600.00 | 65,373,330.00 | 1,165,270.00 | 98.2 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 66,538,600.00 | 65,373,330.00 | 1,165,270.00 | 98.2 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 66,538,600.00 | 65,373,330.00 | 1,165,270.00 | 98.2 |
| АРГА ХЭМЖЭЭ 81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 31,596,500.00 | 30,965,115.00 | 631,385.00 | 98.0 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 31,596,500.00 | 30,965,115.00 | 631,385.00 | 98.0 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 31,596,500.00 | 30,965,115.00 | 631,385.00 | 98.0 |
| Норматив зардал | 31,596,500.00 | 30,965,115.00 | 631,385.00 | 98.0 |
| АРГА ХЭМЖЭЭ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 154,400.00 | 115,000.00 | 39,400.00 | 74.5 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 154,400.00 | 115,000.00 | 39,400.00 | 74.5 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 154,400.00 | 115,000.00 | 39,400.00 | 74.5 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 154,400.00 | 115,000.00 | 39,400.00 | 74.5 |
| АРГА ХЭМЖЭЭ 81834 Боловсролын стандарт, сургалты | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 317,030,125.00 | 308,553,958.47 | 8,476,166.53 | 97.3 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 317,030,125.00 | 308,553,958.47 | 8,476,166.53 | 97.3 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 317,030,125.00 | 308,553,958.47 | 8,476,166.53 | 97.3 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 258,777,400.00 | 258,676,167.47 | 101,232.53 | 100.0 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх | 32,756,525.00 | 32,756,525.00 | - | 100.0 |
| Хангамж, бараа материалын зардал | 5,993,700.00 | 5,924,166.00 | 69,534.00 | 98.8 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 16,096,700.00 | 7,911,500.00 | 8,185,200.00 | 49.1 |
| Томилолт, зочны зардал | 144,100.00 | 24,000.00 | 120,100.00 | 16.7 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний | 816,900.00 | 816,800.00 | 100.00 | 100.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 2,444,800.00 | 2,444,800.00 | - | 100.0 |
| АРГА ХЭМЖЭЭ 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 17,920,575.00 | 17,920,574.75 | 0.25 | 100.0 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 17,920,575.00 | 17,920,574.75 | 0.25 | 100.0 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 17,920,575.00 | 17,920,574.75 | 0.25 | 100.0 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 15,929,400.00 | 15,929,399.75 | 0.25 | 100.0 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх | 1,991,175.00 | 1,991,175.00 | - | 100.0 |

*Эх сурвалж: Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар өмнөх оны аудитаар төлбөрийн акт тогтоож төвлөрүүлсэн 1000,0 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 51016,2 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

дэмжлэг 16663,5 мянга нийт 77649,7 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж ангилал зориулалтын дагуу зарцуулсан байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс 127 мэдээллийг байршуулсан. Үүнээс хугацаа хоцорсон 21 байршуулаагүй 3 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 128221,4 мянга, зарлагын 29107,6 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*Хүснэгт-3 Шилэн дансны мэдээлэл*

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд нь байршуулсан | Хугацаа болоогүй | Хугацаа хоцроож байршуулсан | Мэдээллийг хугацаандаа байршуулаагүй | Үүнээс Хугацаа хоцроож байршуулсан: Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт | Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан | Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан | Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр | Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад | Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ /мян.төг/ | | | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Тоо | Тоо | | | Тоо | Тоо | | | Тоо | Орлого | Зарлага | Тоо | Дүн |
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | 2 | 1 | 3 | 1 | | 1 | 1 | | | | 1 | | | | | |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | 0 | | | | | | | | | | | | | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | | 0 | | | | | | | | | | | | | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 32 | | 3 | | 3 | | | | | | | | | | | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 86 | | 17 | | | 4 | | | 2 | 3 | 1 | | 3 | 97,636 | 29,108 | 4 | 30,585.0 |
| | Нийт | 27 | 151 | 134 | 2 | 21 | 3 | 4 | 4 | 1 | 1 | 2 | 3 | | | 3 | 97,636 | 29,108 | 4 | 30,585.0 |

*Эх сурвалж: Байгууллагын шилэн дансны цахим сангаас*

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 21611,7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 15491,7 мянган төгрөгийг 3 төлбөрийн акт тогтоосныг барагдуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх 6120,0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг биелэлтийг 2020.04.01 ний өдрийн 24 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

*Хүснэгт 4.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь | |
| Төлбөрийн акт | 3 | 15491.7 | 3 | 15491.7 | | | | |
| Зөвлөмж | 2 | 6120 | 2 | 6120 | | | | |
| Нийт дүн | 5 | 21611.7 | 5 | 21611.7 | | | | |

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11655,8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2124,4 мянган төгрөгийн алдааг залруулж, 3651,9 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 2411,5 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 3468,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө. /Хавсралт 1/

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ

Тайлант онд Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 345,4 мянган төгрөгөөр дутуу байгуулсан, эм хэрэгслийн зардлаас 225,0 мянган төгрөгийн 9 кварцын гэрэл, 12 сард авсан 1414,0 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгслийг үлдэгдлээр байхад зарлага гаргасан, Бэлтгэн нийлүүлэгч ААНБ-аар хүүхдийн шкаф хийлгэхээр 1675,0 мянган төгрөгийг шилжүүлж хөрөнгийг аваагүй байхад орлого авсан.

**Шийдвэрлэсэн нь**:Санхүүгийн тайланд залруулж хөрөнгийг бүртгэсэн.

## Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 9521,4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 3651,9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож 2411,5 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 3468,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

1.Тус байгууллага нь 2020.12.23 нд "Хонгор мөнгөн үсэг"-ХХК-аар хүүхдийн шкаф хийлгэхээр 1675.0 мянган төгрөгийг шилжүүлж, мөнгийг бэлнээр гаргуулж авсан байхад санхүүгийн тайланд хөрөнгөөр тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, заалттай нийцэхгүй, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>**Шийдвэрлэсэн нь:**</u>Төлбөрийн акт тогтоож буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр шийдвэрлэв.

2. Цалингийн зардлыг давтан тооцоолол хийхэд 4 дүгээр сард 3 ажилтан цалингийн зөрүүг олгохдоо татвар, шимтгэлийг суутган тооцоогүй 58.5 мянган төгрөгийг илүү олгосон, сахилгын шийтгэлтэй 2 албан хаагчид 1344,3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, ХХОАТ- зардлыг 573,9 мянган төгрөгөөр илүү шилжүүлж, авлагаар тусгаагүй, санхүүгийн тайланд зардал нэмэгдүүлж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.3 дахь “Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно.” гэсэн заалттай нийцэхгүй, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>**Шийдвэрлэсэн нь:**</u>Төлбөрийн акт тогтоож татварт илүү шилжүүлсэн 573,9 мянган төгрөгийг суутган тооцож төлөх, 1402,9 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр шийдвэрлэв.

3.Цалин хөлсний суутган тайланг гаргахдаа 4 ажилтны 2387.5 мянган төгрөгийг дутуу, Б.Гантулгын цалинг 1125.8 мянган төгрөгөөр илүү мэдээлж нийт 1261.6 мянган төгрөгийн цалинг дутуу тайлагнаж, өглөг, авлагын тооцоо нийлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Хувь хүний орлогын албан татварын тухай 25.4 “Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ.”, 26 дугаар зүйл 26.1 “Албан татвар төлөгч энэ



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

хуулийн дагуу албан татвар ногдуулах орлогоо өөрөө үнэн зөв тодорхойлж, доор дурдсан хугацаанд албан татварыг холбогдох төсөвт төлнө”

**Шийдвэрлэсэн нь:** Цалин хөлсний суутганы тооцоог нийлж, зөрүүтэй мэдээлсэн албан хаагчдын цалингийн мэдээг залруулж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

4.Нийгмийн даатгалын мэдээг тулган шалгахад 4 дүгээр сард 4 албан хаагчийн 720990 төгрөг, 12 сард нэг албан хаагчийн 317653 төгрөг, нийт 1149923 мянган төгрөгийн цалинг НДХ-д дутуу мэдээлсэн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Ажиллагсдын дутуу мэдээлсэн цалингийн санг нөхөн мэдээлж, баталгаажуулан зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

5.Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс 127 мэдээллийг байршуулсан. Үүнээс хугацаа хоцорсон 21 байршуулаагүй 3 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 128221,4 мянга, зарлагын 29107,6 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

6. Байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 20 ний өдрийн А/45 дугаар тушаалаар томилсон тооллогын комисс нь эд хөрөнгийг данс бүрээр хөрөнгийн журналаар тоолоогүй, ажилтнуудын картаар тоо ширхгээр тоолсон нь бүртгэлтэй хөрөнгүүдийг ажилтнуудын картад бүрэн бүртгэж тоологдсон эсэхийг нотлох боломжгүй. комиссын хурлын тэмдэглэл, илтгэх хуудас байхгүй, тооцоо бодсон акт, эрхлэгчийн тушаалаар баталгаажуулаагүй, нягтлан бодогч, нярвын тайлангийн үлдэгдлээс 6117,5 төгрөгөөр зөрүүтэй нотлох боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Оршин байх”, “Үнэлгээ” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын өмч хөрөнгийн тооллогыг 2021.04.01-ны дотор хийж баталгаажуулан зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 3468,0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

1. Тайлант онд бэлтгэн нийлүүлэгч аж ахуй нэгж байгууллагад хөрөнгө худалдан авахаар мөнгө шилжүүлж бэлнээр гаргуулан авч өөр зүйлд зарцуулдаг, Нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтад үндэслэн бүртгэж, нярвын тайлан гараагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгадаг явдлыг



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

таслан зогсоож, цаашид зөрчлийг давтан гаргаж байгаа талаар дараагийн аудитаар анхаарч үзэх.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***1. Зардлын данстай холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:* Тайлант онд нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас дрож худалдан авахаар 3468.0 мянган төгрөгийг "Хонгор мөнгөн үсэг" ХХК-д шилжүүлж тухайн аж ахуй нэгж байгууллагаас худалдан авалтыг хийгээгүй, мөнгийг бэлнээр гаргуулан өөр бэлтгэн нийлүүлэгчээс авч зардлыг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн

*1.2.Эрсдэл:* Зардлыг зориулалт бусаар зарцуулж, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах.

*1.3.Өгсөн зөвлөмж:* Нормын хувцас зөөлөн эдлэл зардлыг зориулалтын дагуу зарцуулах, аж нэгж байгууллагаас бэлэн мөнгийг гаргуулж авдаг явдлыг таслан зогсоож. Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын дагуу зардлыг бүртгэж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.
*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* *Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР Г.ГАНЧИМЭГ 2021.02.24

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ 2021.02.24

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ 2021.02.24



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/58/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэг | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тус байгууллага нь 2020.12.23 нд "Хонгор мөнгөн үсэг"-ХХК-аар хүүхдийн шкаф хийлгэхээр 1675.0 мянган төгрөгийг шилжүүлж, мөнгийг бэлнээр гаргуулж авсан байхад санхүүгийн тайланд хөрөнгөөр бүртгэсэн. | 1675.0 | Төлбөрийн акт тогтоох | Эрхлэгч, нягтлан бодогч | Д, Уранчимэг, Э.Билгүүн |
| 2 | Цалингийн зардлыг давтан тооцоолол хийхэд 4 дүгээр сард 3 ажилтан цалингийн зөрүүг олгохдоо татвар, шимтгэлийг суутган тооцоогүй 58538 төгрөгийг илүү олгосон, сахилгын шийтгэлтэй 2 албан хаагчид 1344390 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, ХХОАТ- зардлыг 573990 төгрөгөөр илүү шилжүүлж, авлагаар тусгаагүй, санхүүгийн тайланд зардал нэмэгдүүлж тайлагнасан | 1976.9 | Төлбөрийн акт тогтоох | Эрхлэгч, нягтлан бодогч | Д, Уранчимэг, Э.Билгүүн |
| 3 | 4 дүгээр сард 4 албан хаагчийн 720990 төгрөг, 12 сард нэг албан хаагчийн 317653 төгрөг, нийт 1149923 мянган төгрөгийн цалинг НДХ-д дутуу мэдээлсэн. | 1149.9 | Албан шаардлага өгөх | Эрхлэгч, нягтлан бодогч | Д, Уранчимэг, Э.Билгүүн |
| 4 | .Цалин хөлсний суутган тайланг гаргахдаа 4 ажилтны 2387.5 мянган төгрөгийг дутуу, Б.Гантулгын цалинг 1125.8 мянган төгрөгөөр илүү мэдээлж нийт 1261.6 мянган төгрөгийн цалинг дутуу тайлагнаж, өглөг, авлагын тооцоо нийлээгүй | 1261.6 | Албан шаардлага өгөх | Эрхлэгч, нягтлан бодогч | Д, Уранчимэг, Э.Билгүүн |
| 5 | Шилэн дансны тухай хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс 127 мэдээллийг байршуулсан. Үүнээс хугацаа хоцорсон 21 байршуулаагүй 3 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 128221,4 мянга, зарлагын 29107,6 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн | | Албан шаардлага өгөх | Эрхлэгч, нягтлан бодогч | Д, Уранчимэг, Э.Билгүүн |
| 6 | Байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 20 ний өдрийн А/45 дугаар тушаалаар томилсон тооллогын комисс нь эд хөрөнгийг данс бүрээр хөрөнгийн журналаар тоолоогүй, ажилтнуудын картаар тоо ширхэгээр тоолсон нь бүртгэлтэй хөрөнгүүдийг ажилтнуудын картад бүрэн бүртгэж тоологдсон эсэхийг нотлох боломжгүй. комиссын хурлын тэмдэглэл, илтгэх хуудас байхгүй, тооцоо бодсон акт, эрхлэгчийн тушаалаар баталгаажуулаагүй, нягтлан бодогч, нярвын тайлангийн үлдэгдлээс 6117,5 төгрөгөөр зөрүүтэй нотлох боломжгүй байна. | | Албан шаардлага өгөх | Эрхлэгч, нягтлан бодогч | Д, Уранчимэг, Э.Билгүүн |
| 7 | Тайлант онд нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас дрож худалдан авахаар 3468.0 мянган төгрөгийг "Хонгор мөнгөн үсэг" ХХК-д шилжүүлж тухайн аж ахуй нэгж байгууллагаас худалдан авалтыг хийлгээгүй, мөнгийг бэлнээр гаргуулан өөр бэлтгэн нийлүүлэгчээс авч зардлыг зориулалт бусаар зарцуулсан. | 3468.0 | Зөвлөмж өгөх | Эрхлэгч, нягтлан бодогч | Д, Уранчимэг, Э.Билгүүн |
| 8 | Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 345,4 мянган төгрөгөөр дутуу байгуулсан, эм хэрэгслийн зардлаас 225,0 мянган төгрөгийн 9 кварцын гэрэл, 12 сард авсан 1414,0 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгслийг үлдэгдлээр байхад зарлага гаргасан, Бэлтгэн нийлүүлэгч ААНБ-аар хүүхдийн шкаф хийлгэхээр 1675,0 мянган төгрөгийг шилжүүлж хөрөнгийг аваагүй байхад орлого авсан. | 2124.4 | Санхүүгийн тайланд залруулга хийсэн | Эрхлэгч, нягтлан бодогч | Д, Уранчимэг, Э.Билгүүн |
| ДҮН | | 11655.8 | | | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАГДМАЛ